

ХҮҮХДИЙН ОЮУНЫ ХӨГЖИЛД ХӨГЖМИЙН УРЛАГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Х.Баасанцэрэн, МУ-ын Гавьяат багш, МУБИС

Abstract: The main purpose of music art is focused on how to provide children with aesthetic and moral ideals; to foster a sense of personal dignity and the view of the world; and finally how to develop their talents and skills using the systematic educational approach. The music art is one of the important and effective tools to build children's mental imagination, develop their language and behavior and to strengthen discipline. Therefore, music education is creating a basic condition to promote the socio-economic sustainability at the local, national, regional, and global levels. Furthermore, there is an urgent need to participate actively in implementation process of music education and to underline a social implication led by the key stakeholders including teachers and parents.

Түлхүүр үг: төлөвшил, мэдлэг, дадал, гоо зүй, авьяас чадвар, ёс суртахуун, оролцоо

Удиртгал

Амьдрал ба урлагт хандах ёс суртахууны хүмүүжил, гоо зүйн мэдрэмж, бие бялдар, оюун ухааны хөгжлийн өв тэгш хослол нь бие хүний шилдэг чанарыг бүхэлд нь төлөвшүүлэх зайлшгүй нөхцөл болдог. Энэхүү төлөвшлийг бага насанд нь бий болгоход хөгжмийн урлаг чухал нөлөөтэй байдаг.

Иймд хөгжмийн урлагийн гол зорилго бол хүүхдэд гоо зүй, ёс суртахууны өв тэгш хүмүүжил олгох, хувь хүний эрхэм чанар болон ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд оршино. Гоо зүй, уран сайхны өндөр үнэ цэнэтэй, хүүхдэд сонирхолтой, тохиромжтой, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны өргөн цар хүрээтэй, мэдлэг болон чадвар, дадлыг олгохуйц урын сан, арга ухааныг ашиглаж энэхүү зорилгыг хэрэгжүүлнэ. Ийнхүү хэрэгжүүлэхдээ уламжлал болон шинэчлэл, онол болон практикийг зохистой хослуулах нь нэн чухал (Жанцанноров, 2009, х.34) юм.

Хөгжим нь биднийг хүрээлэн буй орчин, амьдралын олон талт юмс үзэгдлийг хөгжмийн хэлээр илэрхийлж байдгийнхаа хувьд хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөн, сэтгэх үйл ажиллагааг идэвхижүүлэхээс гадна хүүхдийн сэтгэхүйн үйлдлийн бусад олон тал болох бүтээлч чадвар, төсөөлөл, уран сэтгэмжийг сэргээн хөгжүүлж,

тодорхой мэдрэмжийг төрүүлдэг. Харин амьдрал дээр бол хөгжим нь сурлага, хөдөлмөрийн амжилт гаргах гол хөшүүрэг болж өгдөг.

Үндсэн хэсэг

Хүүхдэд хөгжмийн авьяас хамгийн түрүүнд хөгжсөнөөр бусад чадварууд нь үүсэж хөгжих нөхцөл нь бүрэлддэг гэдгийг эрдэмтэд судалгаагаар нотолжээ. АНУ-д саяхан дунд сургуулийн 25.000 хүүхдийг хамарсан судалгаа хийхэд, математикийн хичээлд онцгой сайн, IQ өндөртэй хүүхдүүдийн 88 % нь хөгжмийн тодорхой авьяас, сонирхолтой болох нь нотлогджээ. Мөн хөгжмийн аль нэг төрлийг сонирхдог, хичээллэдэг хүүхэд огт сонирхож, хичээллэдэггүй хүүхдээс 35-44 % илүү гадаад хэлний авьяастай болох нь харагдсан байна (Оюунбилэг нар, 2008, х.59). Мөн хөгжим тоглодог хүүхдэд математик, логик сэтгэлгээ илүү төлөвшдөг ажээ.

Хүүхдийн сэтгэхүйн төсөөлөл, хэл яриаг хөгжүүлэх, зан төлөвийг төлөвшүүлэн тогтоох, хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд хөгжмийн урлаг нь чухал хэрэглүүрийн нэг болдог. Хэрэглүүр болох үүднээс нь дэлгэрүүлэн тайлбарлавал дараах мэт байна.

Гоо зүйн хүмүүжил олгох үндсэн хэрэглүүрийн нэг бол хөгжим мөн. Хүүхдэд олгох гоо зүйн хүмүүжил нь урлаг, уран сайхны янз бүрийн төрлөөр дамжин хүүхдийн бүтээлч авьяасыг илрүүлж, сайн муу, зөв буруу, сайхан муухайг ялган таньж, аливаа зүйлийг хүртэн мэдэрч ухааран ойлгодог болгоход чиглэгддэг (Лувсанвандан, 1971, х.9).

Хөгжим нь юуны өмнө хүүхдийн хөгжмийн авьяас билгийг хөгжүүлэхэд үйлчлэх ёстой. Хүүхдийн хөгжмийн ерөнхий авьяас билэг хөгжиж байгааг илрүүлэх ямар үндсэн шинж тэмдэг байдаг вэ?

Хөгжмийн авьяас билэг хөгжиж байгаагийн хамгийн анхны илрэл, шинж тэмдэг бол хөгжмийг хүртэн мэдэрч, сэтгэлийн хөдөлгөөний зохих өнгө аясаа илэрхийлэх чадвар байдаг. Хөгжим нь хүүхдийн сэтгэлийг хөдөлгөж, үйл ажиллагааны шинэ төрөл, үйл хөдөлгөөнд татан оруулж, амьдралын янз бүрийн үзэгдэлтэй танилцуулан, энэ чанараараа амьдралын туршилтыг нь нэмэгдүүлдэг.

1. Хөгжмийн ерөнхий авьяас билэг хөгжиж байгаагийн илэрхийлэл, шинж тэмдэг нь хөгжмөөр илэрч байгаа хурц, тод, ойлгомжтой үзэгдлүүдийг харьцуулан үнэлж дүгнэн сонсох чадвар юм. Энэ чадвар нь тухайн сонсогчоос хөгжмийн санааг утга төгөлдөр илэрхийлж байгаа уран илэрхийллийн аль нэг хэрэглүүрийг хүртэх зориудын анхаарал, хөгжим сонсож ойлгох хамгийн наад захын эгэл жирийн соёлыг шаарддаг. Жишээ нь: хөгжмийн авианы эгэл жирийн шинжийг /авиа эгшгийн чанга, сул, төгөлдөр хуур зэрэг хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэлт/ ялгааг жишин харьцуулж, хөгжмийн зохиолын хамгийн энгийн бүтцийг /дууны үндсэн дахилт, түрлэг г.м./ ялган таньж, уран сайхны дүрээр илэрч байгаа эрс ялгаатай санааг /хайрлан энхрийлсэн эсвэл хөөр хөгжилтэй/ ойлгон ухаарч сонсож байдаг. Ийм замаар хүүхдийн сонсох ба дуулах дуртай зохиолууд байнга нэмэгдэн хуримтлагдаж, хөгжмийн тансаг сайханд амтархан дурлах анхны суурь тавигддаг байна.

2. Хөгжмийн ерөнхий авьяас билэг хөгжиж байгаагийн гурав дахь илрэл буюу шинж тэмдэг нь хүүхэд хөгжим сонсоод зогсохгүй, уран сайхны дүрээр төсөөлөн авч, түүнийгээ өөрийн дуу, бүжиг, тоглоомд тусган хэрэглэх бүтээлч хандлагын илрэл байдаг. Жишээ нь, хүүхэд бие даан тоглохдоо туулайны онцлогийг гаргахын тулд цовоо сэргэлэн дэгдэн үсэрч, баавгайн онцлогийг гаргахын тулд хүндээр гишгэж явах гэх мэтээр тохирох хөдөлгөөнийг эрж хайж оруулж байдаг. Мөн мэдсэн бүхнийгээ хөдөлгөөндөө шингээж, шинэ санаа гаргаж, бүжгийн зохиомжийг өөрчилдөг (Пүрэвсүрэн, 2011, х.3). Ийнхүү хүүхдийн ерөнхий авьяас билэг хөгжсөнөөр тэдэнд бүтээлч дүрслэл төрж, хөгжмийн сонсгол нарийсан, сэтгэлийн хөдөлгөөн нь улам бүр өрнөдөг.

Хөгжим бол хүүхдийн ёс суртахууныг төлөвшүүлэх үндсэн хэрэглүүрийн нэг мөн. Хөгжим нь хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөнд нөлөөлж, түүний ёс суртахууны төлөв байдлыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй (Жанчив, 1991, х.12). Хөгжим нь тухайн үед яриа заавраас илүү хүчтэй нөлөөлөл үзүүлэх бөгөөд янз янзын онцлог шинж байдал бүхий хөгжимтэй хүүхдийг танилцуулснаар түүний уран санаа, уянга эгшиг нь бяцхан сонсогчдын сэтгэлийг эзэмдэж, илүү бодол санаашрал, баяр баясгаланд татан оруулдаг. Дуу хөгжим сонсох, хөгжим тоглох, хөгжимт хөдөлгөөн хийх гэх мэт ээлж дараалал нь хүүхдээс их анхаарал, ухаан бодол, авхаалж самбаа, үйл хөдөлгөөний шалмаг өөрчлөлт, шийдэл, зохион байгуулалтыг шаарддаг.

Ёс суртахууныг бүрэлдүүлэх үндсэн хэрэглүүрийнх нь хувьд найрал дуун дээр жишээ авъя. Найрал дууны урлаг нь нийтээрээ зөв дуулах чадварт үндэслэгддэг. Зөв дуулах гэдэгт аялах дадал эзэмших, аялгууг зөв гаргах, үгийг тод дуудах, амьсгал зөв авах ба бусдынхаа өнгийг чагнаж жигд дуулах, хөгжмийн хэмнэлд зохицуулах зэрэг олон үйлдлүүд хамаардаг. Зөв дуулалт нь шаргуу, хөдөлмөрч, дэг журамтай, анхааралтай байх зарчимд үндэслэнэ. Мөн аливаа дууг дуулахдаа хамт олонтойгоо зэрэг эхэлж, зэрэг төгсгөх, бүжиг хөдөлгөөнөө хөгжимтэй зохицуулах, бусдыг хүндэтгэж, өөрийн хүсэл сэтгэлийг барьж тэвчиж сурах зэрэг нь зоригийн их хүчийг шаарддаг.

Нийтээрээ гүйцэтгэх дуу, хөгжим, бүжиг, тоглоом нь хүүхдийг нэгдмэл нэгэн санаатай хамт олонч үзэлд чиглүүлж, хүмүүжлийн зорилтыг амжилттай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал, дуу нь хамсах дуулаачдаас нэгдмэл хүчийг шаарддаг. Хэн нэг нь буруу дуулбал зөв сайн дуулж байгаа бусдыгаа баллах гэмтэй тул нэгдэж дуулах шаардлага гардаг. Энэ нь угтаа эвсэг, хамт олонч чанар төлөвшүүлэх, хувийн харьцаа хандлагаа зөв илэрхийлж сурахад нөлөөлдөг байна.

Ийм байдлаар хөгжмийн үйл ажиллагаа хүүхдэд хувь хүний ёс суртахууны үндсэн чанар бүрэлдэн тогтох зайлшгүй чухал нөлөөлөл нь болж энэ үндсэн дээр ирээдүйн иргэний соёлт, ёс суртахууны анхны үндсэн суурь тавигддаг.

Хөгжим бол оюун ухаан, авьяас чадварыг идэвхижүүлэх хэрэглүүр мөн. Хөгжмийг ойлгож тусгах явдал бол оюун ухааны үйл ажиллагаатай нягт холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, оюун ухааны хөгжлийн чухал чанар болдог анхаарал, ажигч байдал, ухаарах чадварыг ихээр шаарддаг. Хүүхэд хөгжим сонсоод аялгууны адил төсөөтэй ба ялгаатай талыг жишин харьцуулдаг (Эрдэнэбат, 1983, х.5). Мөн хөгжмийн утга төгөлдөр санаатай танилцах явцад уран сайхны дүрийг тодорхойлж, хөгжмийн зохиолын бүтэц, агуулгыг ялган таньж сурдаг.

Үндэсний, сонгодог, орчин үеийн дуу, хөгжим, бүжиг нь тухайн ард түмний зан заншлаас эхлээд нийт хүн төрөлхтний хөгжил дэвшлийг хүүхдэд таниулж, интернационалч сэтгэл хөдлөлийг хүүхдэд төрүүлдэг.

Хөгжим сонсох явцад үүссэн сэтгэлийн хөдөлгөөний янз янзын өнгө аяс нь хүүхдийн оюун санааны ертөнц хүсэл мөрөөдөл, санаа бодлыг үргэлж баяжуулж хөгжүүлж байдаг билээ.

Хөгжим бол бие бялдрыг хөгжүүлэх хэрэглүүр мөн. Хөгжим нь хүний сонороор дамжин бие организмд бүхэлд нь нөлөөлж, түүнийг идэвхитэй горим үйлд татан оруулж, тухайн хүний зүрх судасны систем, амьсгалын үйл ажиллагааг идэвхижүүлдэг. Дуу нь хүүхдийн хоолойн аппарат, дууны хөвчийг бэхжүүлэн, хэл яриаг сайжруулан сонсголыг улам хөгжүүлдэг. Дуулах үед биеэ зөв авч дуулах нь амьсгааг улам гүнзгийрүүлэн зохицуулдаг. Хөгжимт хөдөлгөөн нь хөгжим ба хөдөлгөөний харилцан үйлдлийн үндсэн дээр явагдаж, хүүхдийн биеийн галбир, хөдөлгөөний тэнцвэр, эв дүй, уян хатан чанарыг нь сайжруулж байдаг. Энэ мэтээр хэрэглүүр болох үүднээс нь хөгжмийн үүрэг, ач холбогдлыг дурдвал их зүйл бий.

Хөгжмийн урлагийн зорилгыг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл бол хүүхдийн нас насны онцлогт тохирсон агуулга бүхий хөгжмийн хичээл юм. Хөгжмийн хичээл нь:

- Дуулах /хүүхдийн бүтээлч чадварыг өрнүүлсэн гоцлол болон найрал дууны үйл ажиллагаа/
- Хөгжим сонсох /хөгжмийг ухамсарлан, хүртэж ойлгох үйл ажиллагаа/
- Соноршуулах /нотны бичлэгт сургаж, хөгжмийн сонсголыг хөгжүүлэх үйл ажиллагаа/ гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Хүүхдэд хөгжмийн боловсролын тулгуур мэдлэг болох хөгжмийн тухай, хөгжмийн зохиолч, хөгжимчдийн тухай, хөгжмийн уран илэрхийллийн хэрэглүүр, төрөл, хэлбэр, нотны бичлэгийн тухай ойлголтыг тодорхой үе шат, дэс дараалалтайгаар тогтмол эзэмшүүлэх ёстой.

Хөгжмийн хичээлийг хүүхдийн нас зүй, бие болон сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохируулан, оновчтой арга хэлбэрээр заах бөгөөд нас нэмэх тутам олгох хүмүүжлийн зорилт нь өөрчлөгдөн гүнзгийрнэ. Энэ тухай жишээлэн авч үзье.

Хүүхэд 2 сартайгаасаа эхлэн ямар нэг дуу чимээ, хөгжим сонсоод хөдөлгөөн нь намждаг.

4-5 сартайдаа дууг чих тавин чагнах, ямар нэг авиа гарч байгаа зүгийг тосон тэмүүлэх зэргээр хөгжмийн авиа эгшгийг ямар нэг хэмжээгээр ялгах оролдлого хийдэг.

Хүүхэд 1 нас хүрмэгц дууг сонсоод түүнийг дуурайж анир чимээ гарган шулганаж эхэлдэг. Энэ үед олгох хөгжмийн хүмүүжил нь тэдний сонорын сэрлийг хөгжүүлж, хөгжмийг түргэн хүлээж авах сэтгэлийн хөдөлгөөнийг төлөвшүүлэхэд чиглэгдэх нь зүйтэй.

2 насны үед хүүхэд хөгжим сонсоод сэтгэл санааны /хөгжүүн, сэргэлэн цовоо, намуун тайван/

янз янзын өнгө аясыг илэрхийлдэг. Сонорын сэрэл нь улам нарийсан хөгжиж, хөгжмийн эгшгийн өндөр, нам, чанга, сулыг ялгаж, хөгжмийн зэмсгүүдийн дуугарах өнгийг /тембр/ таних чадвартай болдог. Насанд хүрэгчдийн дуулахыг дуурайн дагаж эхэлдэг. Мөн алга ташин дороо дэвсэх, тойрог болох зэрэг энгийн хөдөлгөөнийг хийж чаддаг.

3-4 насны үед хүүхдийн мэдрэмж эрс сайжирч, хөгжмийн шинжийг илүү нарийн ялган таних боломжтой болдог. Түүнчлэн хүүхэд бүрийн сонорын мэдрэхүйн ялгаа энэ насанд хурц тод илэрдэг. Тийм ч учраас зарим хүүхэд дуу, хөгжмийг хялбар сурч байгаа нь харагддаг. Мөн насанд хүрэгчдийн тусламжтайгаар богино хэмжээний дууг бие даан дуулж, бүжгийн энгийн хөдөлгөөнүүдийг эзэмшин түүнийгээ чөлөөт цаг ба тоглох явцдаа бие даан ашиглах чадвартай байдаг.

5 нас нь хүүхдийн идэвхитэй, сониуч зангаар тодорхойлогдож, юм бүхнийг ухаарч мэдэхийг эрмэлзэж байдаг онцлог үе юм. Энэ үед хөгжмийн өөрт тааламжтай, тааламжгүй хэсгийг ялгахаас эхлээд, түүнд тодорхой үнэлэлт өгөх чадвартай болж, авьяас нь улам бүр тодордог.

6-7 насанд сонорын сэрэл сайжирч, хөгжмийн сонсгол бүрэн сууж, хөгжмийн шинж чанарыг тусгасан сэтгэлийн хөдөлгөөний чанар сайжирч, түвшин дээшилнэ.

Хүүхдийг сургуулийн бага ангид орох үед нь хөгжмийн хичээл дээр дуулахдаа дохих, бүжиг хийх, хөгжмийн эгшиглэлтээр алхах зэрэг хөгжимт хөдөлгөөний дасгалыг тогтмол хийлгэх нь ашиг тустай байдаг. Ийм дасгалын явцад хүүхэд хөгжмийн зохиолын дүрслэл, шинж төрхийг гүн ойлгож, хэмнэл, хүчдэл, аялгууны ойлголттой хялбар танилцах бөгөөд ингэснээр сонирхол нь өрнөж, хөгжмийн мэдрэхүйн чадвар нь түргэн бүрэлдэж, хөгжмийн хичээл төдийгүй бусад хичээлийн үр дүн дээшилнэ. Мөн хөдөлгөөн нь хичээлийг баяжуулж, хүүхдийг хөгжөөн идэвхижүүлж, тэдний ичимтгий, бүрэг байдлыг нь арилгаж, ядаргааг нь тайлдаг.

ДҮГНЭЛТ

Ийнхүү хөгжмийн боловсролыг хүүхдэд олгохдоо хүүхдийн нас, бие, сэтгэлийн онцлогт тохируулан, хүүхдийн хөгжмийн сонирхол, хэрэгцээ, авьяас чадварыг нь тооцож, орчин үетэй нягт холбож, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлаж, ололт дэвшлээр тогтмол баяжуулж, байнгын бөгөөд дэс дараалалтай үйл

ажиллагаа зохион байгуулах нь нэн чухал юм.

Хөгжмийн урлагийн боловсрол нь орчин үеийн хүний зайлшгүй эзэмшвэл зохих зүйл гэдгийг ямагт анхаарах хэрэгтэй. Хөгжмийн боловсролын үр ашиг, ач холбогдлыг дөрвөн түвшинд авч үзэж болно. Үүнд:

- Нийгмийн амьдралд амжилт олох
- Ажил, сургууль дээрээ амжилт олох
- Оюуны хөгжилд амжилт олох
- Ахуй амьдралдаа амжилт олох үндэс болно.

Хүүхдийг мэдлэг боловсролтой, соёлт хүн болгон хүмүүжүүлэхэд хөгжмийн урлагийн үүрэг асар их бөгөөд энэхүү үүргийг ухамсарлаж, дээр дурдсан үр ашгуудыг нь бодитой хүртэж чадсанаар тухайн орон нутаг төдийгүй, улс орон, бүс нутаг, цаашлаад дэлхий дахины нийгэм, эдийн засаг тогтвортой хөгжих гол нөхцөл бүрдэх нь дамжиггүй юм. Багш, эцэг эх, бусад оролцогч тал энэ бүхнийг ямагт санаж ажиллах ёстой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Жанцанноров, Н. (2009). *Хөгжмийн онолын хичээлийн толь бичиг*. Улаанбаатар
- Жанчив, Ч. (1991). *Хөгжмийн хичээлийн хүмүүжүүлэх үр нөлөө*. Улаанбаатар
- Лувсанвандан, С. (1971). *Гоо зүйн хичээлийг хөгжүүлэх нь*. Улаанбаатар
- Оюунбилэг, Ч., Баасанцэрэн, Х., Энхжаргал, Н. (2008). *Хөгжмийн боловсролын хичээлийн 1, 2, 3 дугаар ангийн багшийн ном* (цуврал). Улаанбаатар
- Пүрэвсүрэн, Б. (2011). *Хөгжмийн хичээл, түүнийг бусад хичээлтэй интеграцилах нь. Сурган хүмүүжүүлэх ухаан сэтгүүл*. Улаанбаатар
- Эрдэнэбат, Ч. (1983). *Хөгжмийн онолын хичээлийн үр дүн. Багш сонин*. Улаанбаатар